



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН  
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2024/11/НА-СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: Ц.Хосжаргал  
Утас: 51261658 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn  
Ахлах аудитор: В.Эрдэнэцогт  
Утас: 51261658 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn  
Аудитор: С.Отгонхорлоо  
Утас: 51261658 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn

Улаанбаатар хот  
2024 он

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал .....	11
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хүрээний хууль эрх зүйн орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	12
3.4.1 Мөнгөн хөрөнгө .....	12
3.4.2 Авлага.....	13
3.4.4 Бараа материал .....	13
3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө.....	14
3.4.6 Үндсэн хөрөнгө.....	14
3.4.7 Өр төлбөр.....	15
3.4.8 Засгийн газрын хувь оролцоо .....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	20
4.1 Ерөнхий зүйл.....	20
4.2 Материаллаг байдал .....	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	21
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	23
5.1 Харьяа байгууллагууд: .....	23
5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч .....	23
5.3 Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчил.....	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ .....	28

**Товчилсон үгийн жагсаалт**

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НДС	Нийгмийн даатгалын сан
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨАБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

## **Асуудлыг онцолсон хэсэг**

Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50.0 хувийг буцаан олгох тухай хуулийн дагуу давхардсан тоогоор 2022 онд 2,087,746 иргэнд 72,652.2 сая төгрөг, тайлант онд 310,994 иргэнд 11,745.1 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

## **Аудитын гол асуудал**

Капитал банкны эрх хүлээн авагчаас 2021-2022 онд 25,028.7 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг хүлээн авч, 9,043.4 сая төгрөгийн хөрөнгийг борлуулснаас тайлант онд 1,286.1 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдсан байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчийн цалингийн хэмжээг 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлсэн, 2023 онд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 550.0 мянган төгрөг болгосон, Засгийн газрын 2023 оны "Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 238 дугаар, "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" 239 дүгээр тогтоолын дагуу тэтгэвэр бодох цалин хөлсөнд хэрэглэх итгэлцүүрийг шинэчлэн баталж, уг итгэлцүүрийг хэрэглэн нийт тэтгэвэр авагчийн тэтгэврийг шинэчлэн бодох, шинэчлэн бодсон тэтгэврийг 10 хувиар нэмэгдүүлэх шийдвэрүүд гарсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ЗАГДЖАВ

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,809,894,883.4	1,946,222,432.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	994,024,826.4	1,248,356,387.3
33	АВЛАГА	797,556,050.7	680,505,967.6
35	БАРАА МАТЕРИАЛ	18,292,406.3	17,338,477.1
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	21,600.0	21,600.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	37,436,415.6	34,529,913.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	37,436,415.6	34,529,913.5
39200	Биет хөрөнгө	34,373,497.4	32,373,661.0
39300	Биет бус хөрөнгө	3,062,918.2	2,156,252.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,847,331,299.0	1,980,752,345.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	20,093,130.3	46,350,007.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,093,130.3	46,350,007.1
41300	Өглөг	3,897,373.6	7,281,365.9
41400	Урьдчилж орсон орлого	16,195,756.7	39,068,641.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,827,238,168.7	1,934,402,338.4
51	Засгийн газрын хувь оролцоо	1,827,238,168.7	1,934,402,338.4
51100	Засгийн газрын оруулсан капитал	12,216,142.7	12,216,142.7
51200	Хуримтлагдсан үр дүн	1,810,602,703.4	1,917,803,452.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,419,322.6	4,419,322.6
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	0.0	(36,579.0)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,847,331,299.0	1,980,752,345.5

**2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан**

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,778,232,377.9	4,797,875,133.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	3,218,634,817.9	4,186,992,091.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	3,218,634,817.9	4,186,992,091.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,574,537.9	23,977,857.1
120	Нийтлэг татварын бус орлого	9,574,537.9	23,977,857.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	550,023,022.1	586,905,185.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,924,770,818.1	4,688,654,320.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,924,770,818.1	4,688,654,320.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,149,034.4	45,719,246.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	20,618,516.6	32,608,610.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,534,816.6	4,062,334.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,068,981.3	1,280,093.6
2104	Хангамж, бараа материалын зардал	800,733.0	1,060,780.3

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	391,850.6	1,011,913.2
2107	Томилолт, зочны зардал	165,507.2	374,458.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,255,210.8	1,435,607.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,313,418.3	3,885,449.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,894,621,783.7	4,642,935,074.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(146,538,440.2)	109,220,812.8
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	7,590.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	62,187.2	77,142.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(146,593,037.3)	109,143,670.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,975,503,260.3		1,975,503,260.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,672,054.3)		(1,672,054.3)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,973,831,206.0		1,973,831,206.0
9	Тайлант үеийн үр дүн	(146,593,037.3)		(146,593,037.3)
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,827,238,168.7		1,827,238,168.7
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,979,500.2)		(1,979,500.2)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,825,258,668.5		1,825,258,668.5
19	Тайлант үеийн үр дүн	109,143,670.0		109,143,670.0
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,934,402,338.4		1,934,402,338.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,033,447,524.0	4,945,185,400.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	3,167,252,726.5	4,151,750,943.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	3,167,252,726.5	4,151,750,943.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,288,636.4	27,212,810.8
120	Нийтлэг татварын бус орлого	21,288,636.4	27,212,810.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	844,906,161.2	766,221,646.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,944,898,531.9	4,690,801,692.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,944,898,531.9	4,690,801,692.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,430,588.5	42,771,256.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	20,610,765.8	32,629,904.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	2,554,788.4	4,063,573.8

СНАГ-2024/11/НА-СТА-ТЕЗ



Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	шимтгэл		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,055,939.3	1,329,450.2
2104	Хангамж, бараа материалын зардал	741,788.8	1,337,464.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,792,179.9	1,145,919.4
2107	Томилолт, зочны зардал	165,507.2	374,458.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,301,176.1	1,498,495.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	208,443.0	391,991.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,914,467,943.4	4,648,030,435.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	88,548,992.1	254,383,708.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	66,200.0	42,116.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	66,200.0	42,116.8
2200	Дотоод эх үүсвэрээр	66,200.0	42,116.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-66,200.0	-42,116.8
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-10,030.3
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	10,030.3
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	88,482,792.1	254,331,560.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	905,542,034.3	994,024,826.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	994,024,826.4	1,248,356,387.3

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,084,327,341,600.00	4,034,969,537,761.99	49,357,803,838.01	98.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,152,690,838,300.00	4,036,152,581,725.94	116,538,256,574.06	97.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,997,981,800.00	42,115,492,948.32	3,882,488,851.68	91.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,929,830,800.00	32,270,733,468.74	2,659,097,331.26	92.4
210101	Үндсэн цалин	18,635,351,900.00	18,288,597,084.97	346,754,815.03	98.1
210102	Нэмэгдэл	9,196,876,300.00	7,788,484,403.55	1,408,391,896.45	84.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,760,087,200.00	2,331,491,600.27	428,595,599.73	84.5
210104	Урамшуулал	4,337,515,400.00	3,862,160,379.95	475,355,020.05	89.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,489,058,000.00	4,017,061,983.30	471,996,016.70	89.5
210201	Тэтгэврийн даатгал	3,052,734,100.00	2,769,992,397.16	282,741,702.84	90.7
210202	Тэтгэмжийн даатгал	359,619,700.00	324,298,932.98	35,320,767.02	90.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	287,583,100.00	257,575,215.64	30,007,884.36	89.6
210204	Ажилгүйдлийн даатгал	72,084,300.00	59,347,184.49	12,737,115.51	



**Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

					82.3
210205	Эрүүл мэндийн даатгал	717,036,800.00	605,848,253.03	111,188,546.97	84.5
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,475,772,800.00</b>	<b>1,329,450,187.72</b>	<b>146,322,612.28</b>	<b>90.1</b>
210301	Гэрэл, цахилгаан	285,966,400.00	228,703,501.39	57,262,898.61	80.0
210302	Түлш, халаалт	863,858,300.00	800,280,447.85	63,577,852.15	92.6
210303	Цэвэр, бохир ус	111,612,500.00	87,489,628.40	24,122,871.60	78.4
210304	Байрны түрээс	214,335,600.00	212,976,610.08	1,358,989.92	99.4
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,451,026,600.00</b>	<b>1,330,207,374.94</b>	<b>120,819,225.06</b>	<b>91.7</b>
210401	Бичиг хэрэг	433,406,700.00	419,986,294.33	13,420,405.67	96.9
210402	Тээвэр, шатахуун	214,082,400.00	138,687,799.00	75,394,601.00	64.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	146,347,200.00	136,363,883.01	9,983,316.99	93.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	25,524,600.00	17,524,198.00	8,000,402.00	68.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	631,665,700.00	617,645,200.60	14,020,499.40	97.8
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,209,796,600.00</b>	<b>1,113,601,935.00</b>	<b>96,194,665.00</b>	<b>92.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	192,572,100.00	170,682,781.00	21,889,319.00	88.6
210604	Урсгал засвар	1,017,224,500.00	942,919,154.00	74,305,346.00	92.7
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>441,532,000.00</b>	<b>374,458,044.50</b>	<b>67,073,955.50</b>	<b>84.8</b>
210702	Дотоод албан томилолт	441,532,000.00	374,458,044.50	67,073,955.50	84.8
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,671,406,500.00</b>	<b>1,497,495,098.12</b>	<b>173,911,401.88</b>	<b>89.6</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	587,531,300.00	529,032,994.00	58,498,306.00	90.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	110,471,500.00	106,611,220.00	3,860,280.00	96.5
210803	Даатгалын үйлчилгээ	55,388,400.00	47,460,601.40	7,927,798.60	85.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	5,568,900.00	3,694,012.04	1,874,887.96	66.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	512,009,100.00	511,221,109.45	787,990.55	99.8
210807	Газрын төлбөр	10,904,000.00	6,143,162.00	4,760,838.00	56.3
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	326,812,600.00	237,239,999.23	89,572,600.77	72.6
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	62,720,700.00	56,092,000.00	6,628,700.00	89.4
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>329,558,500.00</b>	<b>182,484,856.00</b>	<b>147,073,644.00</b>	<b>55.4</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	97,600,000.00	1,368,000.00	96,232,000.00	1.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	231,958,500.00	181,116,856.00	50,841,644.00	78.1
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,106,692,856,500.00</b>	<b>3,994,037,088,777.62</b>	<b>112,655,767,722.38</b>	<b>97.3</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,106,692,856,500.00</b>	<b>3,994,037,088,777.62</b>	<b>112,655,767,722.38</b>	<b>97.3</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,105,172,299,900.00	3,992,736,472,607.61	112,435,827,292.39	97.3
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	323,809,700.00	305,998,702.38	17,810,997.62	94.5



**Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,195,246,900.00	994,418,717.63	200,828,182.37	83.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	198,750.00	1,301,250.00	13.3
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>-68,363,496,700.00</b>	<b>-1,183,043,963.95</b>	<b>-67,180,452,736.05</b>	<b>1.7</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	-68,363,496,700.00	-1,183,043,963.95	-67,180,452,736.05	1.7
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,084,327,341,600.00</b>	<b>4,270,426,617,691.94</b>	<b>-186,099,276,091.94</b>	<b>104.6</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>774,367,125,300.00</b>	<b>764,351,664,663.92</b>	<b>10,015,460,636.08</b>	<b>98.7</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	774,367,125,300.00	764,351,664,663.92	10,015,460,636.08	98.7
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,378,153,713,000.00</b>	<b>3,500,430,850,277.30</b>	<b>-122,277,137,277.30</b>	<b>103.6</b>
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,378,153,713,000.00	3,500,430,850,277.30	-122,277,137,277.30	103.6
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>170,000,000.00</b>	<b>6,827,146,714.67</b>	<b>-6,657,146,714.67</b>	<b>4,016.0</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	6,785,811,480.41	-6,785,811,480.41	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	170,000,000.00	41,335,234.26	128,664,765.74	24.3
<b>37</b>	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	<b>-68,363,496,700.00</b>	<b>-1,183,043,963.95</b>	<b>-67,180,452,736.05</b>	<b>1.7</b>
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-68,363,496,700.00	-1,183,043,963.95	-67,180,452,736.05	1.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	994,023,846,770.67	-994,023,846,770.67	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,248,354,763,094.78	-1,248,354,763,094.78	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>2,995</b>	<b>2,793</b>	<b>202</b>	<b>93.3</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>35</b>	<b>35</b>	<b>-</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	35	35	-	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>1,480</b>	<b>1,379</b>	<b>101</b>	<b>93.2</b>
620001	Удирдах ажилтан	45	42	3	93.3
620002	Гүйцэтгэх ажилтан	1,250	1,192	58	95.4
620003	Үйлчлэх ажилтан	185	145	40	78.4
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>1,480</b>	<b>1,379</b>	<b>101</b>	<b>93.2</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1,267	1,102	165	87.0
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	12	10	2	83.3
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	201	267	-66	132.8

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>693,293,406.02</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>654,664,606.02</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>496,816,764.02</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>359,171,139.17</b>

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210101	Үндсэн цалин		17,442,280.00
210102	Нэмэгдэл		256,191,118.20
210104	Урамшуулал		85,537,740.97
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>46,511,804.23</b>
210201	Тэтгэврийн даатгал		32,928,511.07
210202	Тэтгэмжийн даатгал		3,631,322.11
210203	ҮОМШӨ-ний даатгал		2,881,145.02
210204	Ажилгүйдлийн даатгал		652,585.23
210205	Эрүүл мэндийн даатгал		6,418,240.80
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>7,257,000.00</b>
210401	Бичиг хэрэг		250,000.00
210402	Тээвэр, шатахуун		2,443,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		4,563,750.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>35,805,439.12</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		6,450,000.00
210604	Урсгал засвар		29,355,439.12
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>1,000,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>47,071,381.50</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		23,141,381.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		23,930,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>157,847,842.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>157,847,842.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		157,847,842.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>38,628,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		<b>38,628,800.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		38,628,800.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>693,937,992.93</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>693,937,992.93</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		16,580,581.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		603,710,551.31
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		71,556,860.12
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,090,000.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		<b>644,586.91</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		979,613.09
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,624,200.00



### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал**

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь эрхэм зорилгоо "Нийгмийн даатгалын үйл ажиллагаанд оролцогч талуудын тэгш оролцоотойгоор нийгмийн даатгалын эрх зүйн орчин, тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгож, төрөөс баримталж буй бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, хүн амны насжилт, хөдөлмөр эрхлэлтийн хэв шинж, тэтгэвэр, тэтгэмж авагчдын тооны байдал зэрэг нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн хүчин зүйлтэй уялдуулан тэтгэврийн даатгалын тогтолцоог шинэчилж, олон давхаргат тогтолцоог бий болгох, хүн амыг нийгмийн даатгалд бүрэн хамруулах, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг өсгөн арвижуулах, нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, иргэдийнхээ нийгмийн баталгааг хангана" гэж тодорхойлжээ.

#### **3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хүрээний хууль эрх зүйн орчин**

Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль, тогтоомж дүрэм журмыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоол "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай"
- Засгийн газрын 2023 оны 238 дүгээр тогтоол "Итгэлцүүр шинэчлэн тогтоох тогтоолд өөрчлөлт оруулах тухай"
- Засгийн газрын 2023 оны 239 дүгээр тогтоол "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай"

Нийгмийн даатгалын сангийн хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/64 дүгээр тушаалаар нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг баталсан байна.

Тус сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 133,421.0 сая төгрөгөөр буюу 7.2 хувиар нэмэгдсэн байна.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,248,356.3 сая төгрөг болж, өмнөх оноос 254,331.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/ сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	993,324.8	1,247,781.3	254,456.5
Төгрөг	993,324.8	1,247,781.3	254,456.5
Төрийн сангийн харилцах	244,746.7	112,922.3	(131,824.4)
Арилжааны банк дахь харилцах	748,565.7	1,134,851.9	386,286.2
Бусад төсөл, нөөцийн харилцах	11.3	5.4	(5.9)
Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.9	1.6	0.7
Замд яваа мөнгөн хөрөнгө	700.0	575.0	(125.0)
<b>Дүн</b>	<b>994,024.8</b>	<b>1,248,356.3</b>	<b>254,331.5</b>


Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 254,331.5 сая төгрөгөөр өссөн нь ҮОМШӨ-ний даатгалын сангийн харилцах 215,726.8 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангийн харилцах 84,630.5 сая төгрөгөөр тус тус өссөн, тэтгэврийн даатгалын сангийн харилцах 14,147.7 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сан 33,118.5 сая төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалжээ.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл сангийн төрлөөр

/ сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тэтгэврийн даатгалын сангийн харилцах	467,076.6	452,928.9	(14,147.7)
Тэтгэмжийн даатгалын сангийн харилцах	117,539.0	202,169.6	84,630.5
ҮОМШӨ-ний даатгалын сангийн харилцах	362,057.6	577,784.4	215,726.8
Ажилгүйдлийн даатгалын сангийн харилцах	38,287.2	5,168.7	(33,118.5)
Эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах	1,541.1	175.4	(1,365.6)
Төвлөрсөн харилцах	6,652.5	9,547.4	2,894.9
Үйл ажиллагааны харилцах	170.9	7.1	(163.8)
Замд яваа мөнгө	700.0	575.0	(125.0)



**Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>Нийт дүн</b>	<b>994,024.8</b>	<b>1,248,356.4</b>	<b>254,331.6</b>
-----------------	------------------	--------------------	------------------

*Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

**Аудитын илрүүлэлт:**

НД төв сангийн Чингис хаан банкны харилцахад байршиж буй мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдэл 94,916.8 сая төгрөг эрсдэлтэй хэвээр байна.

**3.4.2 Авлага**

Авлага дансны эцсийн үлдэгдэл 680,505.9 сая төгрөг болж, өмнөх оноос 117,050.1 сая төгрөгөөр буурсан байна.

**Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл**

*/сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төлбөртэй үйлчилгээний авлага	354,357.6	399,910.5	45,552.9
Татаас, санхүүжилтийн авлага	359,832.6	197,940.8	(161,891.8)
Бусад авлага	83,365.7	82,654.2	(711.5)
Байгууллагаас авах авлага	83,294.4	82,587.3	(707.1)
Хувь хүмүүсээс авах авлага	71.3	66.8	(4.5)
<b>Дүн</b>	<b>797,556.0</b>	<b>680,505.9</b>	<b>(117,050.1)</b>

*Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 14.7 хувиар бууралтад татаас, санхүүжилтийн авлагын 161,891.8 сая төгрөгийн өөрчлөлтөөс голлон нөлөөлжээ.

Татаас, санхүүжилтийн авлага нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль, Засгийн Газрын 2020 оны 140 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журам"-ыг хэрэгжүүлэх хүрээнд үүссэн авлага байна.

Байгууллагаас авах авлагын үлдэгдэлд Капитал банкны эрх хүлээн авагчаас авах авлага 68,201.5 сая төгрөг, 2006 оноос үүссэн олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй иргэн, аж ахуй нэгж байгууллагаас авах 6,444.7 сая төгрөгийн авлага, түрээсийн авлага 99.7 сая төгрөг, улсын байцаагчийн актаар тогтоогдсон шимтгэлийн нөхөн төлбөр болон торгуулийн авлага тус тус бүртгэлтэй байна.

**Аудитын илрүүлэлт:**

- НД төв сангийн нийт 74,646.3 сая төгрөгийн барагдаагүй авлага, үүнээс олон жилийн насжилттай, эзэн холбогдогч тодорхойгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй 6,444.7 сая төгрөг, капитал банкны барагдаагүй авлагын үлдэгдэл 68,201.5 сая төгрөг;
- Баянзүрх дүүргийн НДХ-ийн иргэн аж ахуйн нэгж байгууллагын нийт 9,083.4 сая төгрөгийн барагдаагүй авлага, үүнээс ААНБ-ын төлбөрийн актын барагдаагүй авлага 139.8 сая төгрөг, НДШ-ийн авлага 8,677.6 сая, бусад барагдаагүй авлага 265.9 сая төгрөг;
- Төв аймгийн НДХ нийт 1,126.1 сая төгрөгөөр тайлант оны нэмэгдсэн авлага;
- Налайх дүүргийн НДХ 211.7 сая төгрөг, Говь-сүмбэр аймгийн НДХ 63.4 сая төгрөгийн тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй;

**3.4.3 Бараа материал**

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 17,338.4 сая төгрөг болж, өмнөх оноос 954.0 сая төгрөгөөр буурсан байна.

**Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл**

*/сая төгрөг/*

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бэлэн бүтээгдэхүүн	17,304.5	15,985.3	(1,319.2)
Хангамжийн материал	987.9	1,353.1	365.2
Бичиг хэргийн материал	63.4	132.2	68.8
Аж ахуйн материал	386.2	649.9	263.7
Сэлбэг хэрэгсэл	87.6	118.7	31.1
Түлш, шатах тослох материал	3.4	5.3	1.9
Барилгын засварын материал	0.2	9.3	9.1
Бусад хангамжийн материал	447.1	437.7	(9.4)
<b>Дүн</b>	<b>18,292.4</b>	<b>17,338.4</b>	<b>(954.0)</b>

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материал худалдан авсан 1,526.8 сая төгрөг, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 147.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, зарцуулсан 2,364.6 сая төгрөг, шилжүүлсэн 263.8 сая төгрөг, бусад зарлагадсан 50.2 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Бэлэн бүтээгдэхүүн дансанд Капитал банкны эрх хүлээн авагчаас нийгмийн даатгалын сангийн өрөнд хүлээн авсан үл хөдлөх хөрөнгө бүртгэлтэй бөгөөд тайлант онд нээлттэй дуудлага худалдаа, хөрөнгийн зуучлал зэргээр худалдан борлуулсантай холбоотой 1,319.2 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Жилийн эцэст 147.7 сая төгрөгийн бараа материалын тооллого хийгээгүй /НДЕГ 122.0 сая төгрөг, Хэнтий аймгийн НДХ 25.7 сая төгрөг/.
- НДС төв сан 2,936.6 сая төгрөгийн Капитал банкны эрх хүлээн авагчаас авсан борлуулагдаагүй үл хөдлөх хөрөнгийн үлдэгдэлтэй.

### 3.4.4 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө данс эцсийн үлдэгдэл 21.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 5. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө	21.6	21.6	-
<b>Дүн</b>	<b>21.6</b>	<b>21.6</b>	<b>-</b>

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгийн дансанд Нийслэлийн Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн конторын барилгын зургийн 21.6 сая төгрөгийн ажил, үйлчилгээг хуримтлуулан бүртгэсэн байна.

### 3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 34,529.9 сая төгрөг болж, өмнөх оноос 2,906.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>34,373.4</b>	<b>32,373.7</b>	<b>(1,999.7)</b>
Барилга, байгууламж, орон сууц	27,905.4	27,277.4	(628.0)

**Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Авто-тээврийн хэрэгсэл	367.3	317.2	(50.1)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	5,235.7	3,990.5	(1,245.2)
Тавилга, аж ахуйн эд хогшил	863.5	776.6	(86.9)
Бусад үндсэн хөрөнгө	1.5	8.6	7.1
Дуусаагүй барилга, байгууламж	-	3.4	3.4
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>3,063.0</b>	<b>2,156.2</b>	<b>(906.8)</b>
Программ хангамж	1,835.3	962.6	(872.7)
Бусад биет бус хөрөнгө	1,227.7	1,193.6	(34.1)
<b>Дүн</b>	<b>37,436.4</b>	<b>34,529.9</b>	<b>(2,906.5)</b>

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн 42.1 сая төгрөг, хандиваар хүлээн авсан 87.2 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 308.9 сая төгрөг, шинэчлэн тогтоосон үнэ болон данс хооронд шилжүүлэн бүртгэсэн 466.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, акталсан хөрөнгө 372.9 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн өгсөн 91.0 сая төгрөг, бусад үнэ шинэчлэн тогтоож шилжүүлэн бүртгэсэн 2,329.1 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

### 3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 46,350.0 сая төгрөг болж, өмнөх оноос 26,256.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,897.4</b>	<b>7,281.4</b>	<b>3,384.0</b>
<b>Өглөг</b>	<b>2,182.6</b>	<b>7,104.3</b>	<b>4,921.7</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	33.6	0.2	(33.4)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,148.4	7,103.5	4,955.1
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	0.6	0.6	-
<b>Бусад өглөг</b>	<b>1,714.8</b>	<b>177.1</b>	<b>(1,537.7)</b>
Байгууллагад төлөх өглөг	1,714.8	177.1	(1,537.7)
<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>16,195.8</b>	<b>39,068.6</b>	<b>22,872.8</b>
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	16,195.8	39,068.6	22,872.8
<b>Дүн</b>	<b>20,093.2</b>	<b>46,350.0</b>	<b>26,256.8</b>

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 26,256.8 сая төгрөгөөр өссөн нь бараа үйлчилгээний зардлын өглөг 4,955.1 сая төгрөгөөр, байгууллагад төлөх өглөг 1,537.7 сая төгрөгөөр буурч, урьдчилж олсон орлого 22,872.8 сая төгрөгөөр өссөнөөс голлон нөлөөлсөн байна.

Бараа, үйлчилгээний зардлын өглөг дансанд хуулиар эрх үүссэн олгогдоогүй тэтгэвэр, тэтгэмжийн 7,103.5 сая төгрөгийн өр бүртгэлтэй байна.

Урьдчилж орсон орлого дансанд сайн дурын болон ажил олгогчийн эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн 39,068.6 сая төгрөгийн илүү төлөлт бүртгэлтэй байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Олон жилийн насжилттай, эзэн холбогдогч нь тодорхойгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажгаагүй 149.8 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй /НД төв сан 39.4 сая төгрөг, Хан-уул



Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

дүүргийн НДХ 39.3 сая төгрөг, Говь-сүмбэр аймгийн НДХ 71.1 сая төгрөг/.

### 3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,934,402.2 сая төгрөг болж, өмнөх оноос 107,164.1 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

/ сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>12,216.1</b>	<b>12,216.1</b>	-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,810,602.7</b>	<b>1,917,803.4</b>	<b>107,200.7</b>
Өмнөх үеийн үр дүн	1,957,195.7	1,808,659.7	(148,536.0)
Тайлант үеийн үр дүн	(146,593.0)	109,143.7	255,736.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,419.3	4,419.3	-
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-	(36.6)	(36.6)
<b>Дүн</b>	<b>1,827,238.1</b>	<b>1,934,402.2</b>	<b>107,164.1</b>

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг ирүүлэхээр заасан. Тус ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хамаарах тухайн жилийн төсвийн орлого, зарлагын болон нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулгыг хавсаргаж ирүүлсэн байна.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн төсөлд нийт орлогыг 4,353,082.2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 4,224,268.4 сая төгрөгөөр тооцон боловсруулж, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Ирүүлсэн төсвийн саналд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг 403,955.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, улсын төсвийн санхүүгийн дэмжлэгийг 1,016,599.8 сая төгрөгөөр бууруулж, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай 2022 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг 3,194,125.3 сая төгрөг, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 545,212.7 сая төгрөг, сангийн зарлагыг 3,748,030.1 сая төгрөгөөр тус тус баталжээ.

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг 206,699.7 сая төгрөг, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 229,154.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн нийт орлогыг 4,175,192.1 сая төгрөгөөр, сангийн зарлагыг 404,660.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 4,152,690.8 сая төгрөгөөр тодотгосон байна. Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан

**Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчийн цалингийн хэмжээг 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлсэн, 2023 онд сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 550.0 мянган төгрөг болгосонтой уялдуулан сангийн орлогыг нэмэгдүүлсэн байна.

Засгийн газрын 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 238 дугаар тогтоолын дагуу тэтгэвэр бодох цалин хөлсөнд хэрэглэх итгэлцүүрийг шинэчлэн баталж, уг итгэлцүүрийг хэрэглэн нийт тэтгэвэр авагчийн тэтгэврийг шинэчлэн бодох, “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 239 дүгээр тогтоолын дагуу шинэчлэн бодсон тэтгэврийг 10 хувиар нэмэгдүүлэх шийдвэр гарсантай холбоотойгоор сангийн зарлагыг нэмсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

#### Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт

Нийгмийн даатгалын санд төвлөрүүлэх нийт орлогыг 4,175,192.1 сая төгрөгөөр батлагдсанаас 4,271,609.6 сая төгрөгийг бүрдүүлж, 102.3 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт 9. Нийгмийн даатгалын сангийн нийт орлого /сая төгрөг/*

Орлогын төрөл	2022 оны гүйцэтгэл	2023 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Тэтгэвэр	2,183,003.7	2,799,543.1	2,862,299.7	102.2	62,756.5
Тэтгэмж	230,885.1	294,728.7	305,044.0	103.5	10,315.2
ҮОМШӨ	202,199.6	244,416.0	277,337.5	113.5	32,921.5
Ажилгүйдэл	52,561.2	62,137.2	62,576.8	100.7	439.6
УТ-ийн дэмжлэг	842,775.7	774,367.1	764,351.7	98.7	(10,015.4)
ЭМДС-аас олгох шилжүүлэг	1,100.0	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>3,512,525.3</b>	<b>4,175,192.1</b>	<b>4,271,609.6</b>	<b>102.3</b>	<b>96,417.5</b>

*Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд тэтгэврийн даатгалын сангийн орлого төлөвлөгөөнөөс 62,756.5 сая төгрөгөөр буюу 2.2 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 10,315.2 сая төгрөгөөр буюу 3.5 хувиар, ҮОМШӨ-ний даатгалын сан 32,921.5 сая төгрөгөөр буюу 13.5 хувиар, ажилгүйдлийн даатгалын сан 439.6 сая төгрөгөөр буюу 0.7 хувиар тус тус давсан байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого 96,417.5 сая төгрөгөөр давж биелсэн нь тайлант онд нийгмийн даатгалд 58.6 мянган ААНБ бүртгэгдэж, өмнөх оноос 3.2 мянган ААНБ-аар нэмэгдсэн, албан журмын болон сайн дурын даатгалд 1,344.6 мянган даатгуулагч хамрагдсанаас шалтгаалжээ.

#### Нийгмийн даатгалын сангийн зарлага

Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага 4,152,690.8 сая төгрөгөөр батлагдсанаас 4,036,152.6 сая төгрөгийг зарцуулж, 97.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

*Хүснэгт 10. Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага /сая төгрөг/*

Даатгалын сангийн төрөл	2022 оны гүйцэтгэл	2023 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Тэтгэвэр	3,031,288.5	3,728,529.6	3,617,018.9	97.0	(111,510.7)
Тэтгэмж	165,942.6	229,981.2	212,480.7	92.4	(17,500.4)
ҮОМШӨ	35,933.9	45,203.5	41,523.0	91.9	(3,680.4)
Ажилгүйдэл	78,685.3	80,295.3	110,174.0	137.2	29,878.6
Үйл ажиллагааны	31,211.2	47,131.9	43,210.9	91.7	(3,921.0)

**Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

зардал					
ДТШ-ийн 50 хувийн буцаалт	72,652.3	21,549.4	11,745.1	54.5	(9,804.2)
<b>Нийт дүн</b>	<b>3,415,713.8</b>	<b>4,152,690.8</b>	<b>4,036,152.6</b>	<b>97.2</b>	<b>(116,538.2)</b>

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд ажилгүйдлийн даатгалын сангийн зардалд 29,878.6 сая төгрөгийн илүү зарцуулсан нь ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо 30.0 мянга болж өмнөх оноос 0.4 мянган хүнээр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тэтгэврийн даатгалын сангийн зардал 97.0 хувь, тэтгэмжийн даатгалын сан 92.4 хувь, ҮОМШӨ-ний даатгалын сан 91.9 хувийн гүйцэтгэлтэй, даатгуулагчийн төлсөн шимтгэлийн 50.0 хувийн буцаалт 54.5 хувь, үйл ажиллагааны зардал 91.7 хувийн зарцуулалттай байна.

Нэг сая ба түүнээс доош төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах сарын хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос албан журмаар болон сайн дураар даатгуулсан даатгуулагчид өөрийнх нь 2022 оны 5 дугаар сараас 12 дугаар сард хариуцан төлсөн тэтгэврийн, тэтгэмжийн, ажилгүйдлийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн 50.0 хувийг сар бүр буцаан олгож, тайлант оны гүйцэтгэлээр давхардсан тоогоор нийт 310,994 иргэнд 11,745.1 сая төгрөгийн буцаан олголтыг шилжүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан тус төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээний зорилтот түвшнийг тусгажээ.

2023 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалд хамрагдсан ажил олгогчийн тооны өсөлт өмнөх жилээс 5.2 хувиар өсөж 58.6 мянгад хүрсэн байна. Нийгмийн даатгалд албан журмын болон сайн дурын дутгуулагчдын тоо өмнөх оноос 5.6 хувиар өсөж 1,344.6 мянгад хүрсэн байна. Нийгмийн даатгалын сангаас давхардсан тоогоор 745.2 мянган хүн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авсан байна.


Хүснэгт 10. Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

Код	Д/д	Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	
29	29.1	<b>Нийгмийн даатгал</b>			
		29.1.1	Нийгмийн даатгалд хамрагдсан ажил олгогчийн тооны өсөлт /өмнөх жилтэй харьцуулсан хувь/	5	5.8
		29.1.2	Нийгмийн даатгалд даатгуулсан даатгуулагчийн тооны өсөлт /өмнөх жилд харьцуулсан хувь/	2.5	3.1

Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар, бодлого хэрэгжилт судалгааны газар

### 3.5.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн



бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 16.6 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгө болон дээд шатны төсвийн захирагчаас 603.7 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2.0 сая төгрөг, нийт 693.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 47.0 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 157.8 сая төгрөг, хөрөнгийн зардалд 38.6 сая төгрөг, эхний үлдэгдлээс 0.9 сая төгрөг нийт 693.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.5 Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл**

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даргын төсвийн багцын хэмжээнд 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлагдаагүй байна.

Харьяа төсвийн шууд захирагчид тайлант онд 81.0 сая төгрөгийн төсөвтэй 2 худалдан авах ажил зохион байгуулахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 31.0 сая төгрөгийн бараа, харуул хамгаалалтын үйлчилгээний 35.7 сая төгрөгийн худалдан авалтыг хийж, төлөвлөгөөнд тусаагүй 24.0 сая төгрөгийн барааг шууд худалдан авсан байна.

#### 4. АУДИТЫН ТАЙЛАН

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хууль эрх зүйн орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах авлагатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүү-нийцлийн аудитын газрын аудитор С.Отгонхорлоо гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор В.Эрдэнэцогт, аудитын менежер Ц.Хосжаргал, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2023 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 01/706 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

##### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.


Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 4,688,654.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 46,886.5 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэх үе шатанд хянаж, дахин тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

##### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн болон энэ хуулийн хүрээнд салбарын хэмжээнд 119 орон тоог сул байснаас 3,921.0 сая төгрөгийн цалинтай холбоотой зардлын хэмнэлтийг бий болгожээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ." гэж зааснаар төв болон орон нутгийн Нийгмийн даатгалын газар, хэлтсүүдэд "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын цахим системд бүртгэлтэй нийт 33 авто тээврийн хэрэгслээс 14 автомашин тус хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллан, цэнхэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэж, 19 автомашин энгийн дугаар хэрэглэж, хуулийн хэрэгжилт 57.6 хувьтай байна.

##### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал



АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний 16 байгууллага 2023 онд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй зөрчилд 1,015.6 сая төгрөгийн 5 албан шаардлага, 1,829.3 сая төгрөгийн 11 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д "төсвийн ерөнхийлөн захирагч" гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 4.1.49-д "дотоод аудит" гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг", 11 дүгээр зүйлийн 11.1.11-д "төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

##### Өгсөн зөвлөмж

Харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод аудитын хяналт шалгалт хангалтгүй байгаа зөрчлийг арилгах зөвлөмж өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 5 албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 40.0 хувьтай байна.

*Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт*

Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	5	172,181.2	2	2,345.2	40.0
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>172,181.2</b>	<b>2</b>	<b>2,345.2</b>	<b>40.0</b>

Өмнөх оны аудитаар өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй дараах албан шаардлагууд байна. Үүнд:

- Чингис хаан банк ХХК-тай 2021 онд байгуулсан "Төлбөр тооцооны үүрэг хэсэгчлэн гүйцэтгэх тухай" гэрээний үүргийг хангуулах, харилцахын үлдэгдлийг барагдуулж ажиллах талаар өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Дээрх мөнгөн хөрөнгөөс тайлант онд 1,189.0 сая төгрөгийг татан төвлөрүүлж, жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 94,916.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй;
- Капитал банкнаас авах авлагын 1,149.9 сая төгрөгийг барагдуулж 68,201.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй;
- Олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй авлагаас 6.3 сая төгрөгийг барагдуулж 6,444.7 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй;

Дээрх хэрэгжилт хангалтгүй, зөрчлийг арилгаагүй тул НДҮЗ-д албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах дараах асуудал байна. Үүнд:

- Чингис хаан банкны харилцах дансанд байршиж буй 94,916.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг тус компанитай 2021 онд байгуулсан "Төлбөр тооцооны үүрэг хэсэгчлэн гүйцэтгэх тухай" гэрээний үүргийг хангуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;
- НДҮЗ-ийн даргын эрхлэх асуудлын хүрээний 13 байгууллагын захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 27 ажилтанд ажилгүй байсан хугацааны цалин, НДШ-ийн 186.3 сая төгрөгийг нөхөн төлүүлэх шийдвэр гарснаас, 185.0 сая төгрөгийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлэхээс, 30.9 сая төгрөгийг нөхөн төлүүлж, 154.1 сая төгрөгийг нөхөн төлүүлээгүй, төсөвт хохирол учруулсан хэвээр байгаа асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,763.7 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс 6,745.6 сая төгрөгийн 32 алдааг залруулж, залруулаагүй 18.1 сая төгрөгийн алдаанд 5 зөвлөмж өгсөн.

Аудитаар нийт 125,571.8 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 10.2 сая төгрөгийн зөрчилд 12 төлбөрийн акт тогтоож, 121,088.2 сая төгрөгийн зөрчилд 32 албан шаардлага, үүнээс хариуцлага тооцуулах 2 албан шаардлага, 4,473.4 сая төгрөгийн зөрчилд 44 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй нийт 110,871.0 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

### 5.1 Харьяа байгууллагууд:

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа газар, хэлтсийн үйл ажиллагааны болон сангийн 36 санхүүгийн тайланг нэгтгэснээс 4 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 30 санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй", 2 санхүүгийн тайланд "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгсөн байна.

Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой 6,763.7 сая төгрөгийн 37 алдааг илрүүлснээс 6,745.6 сая төгрөгийн 32 алдааг залруулж, залруулаагүй 18.1 сая төгрөгийн алдаанд 5 зөвлөмж өгсөн байна.

Аудитаар нийт 110,487.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 10.2 сая төгрөгийн зөрчилд 12 төлбөрийн акт тогтоож, 106,004.2 сая төгрөгийн зөрчилд 30 албан шаардлага, 4,473.4 сая төгрөгийн зөрчилд 44 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар үзсэн нийцлийн асуудлаар 0.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1,070.5 сая төгрөгийн 8 албан шаардлага хүргүүлж, 1,841.7 сая төгрөгийн 18 зөвлөмж хүргүүлсэн байна.

### 5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

#### Албан шаардлага

1. НДҮЗ-ийн 2021 оны 24 дүгээр тогтоол, 2022 оны 01 тогтоолуудаар Капитал банкны эрх хүлээн авагчаас хүлээж авсан хөрөнгөөс 15,084.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө борлогдоогүй байгаа нь цаашид ашиглалтгүй хөрөнгө нэмэгдэх эрсдэлтэй байна. Энэ нь НДҮЗ-ийн 2021 оны "Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам" 18 дугаар тогтоолоор баталсан 4.3-т "хөрөнгийн хадгалалт хамгаалалтад НДЕГ-ын өмч хамгаалах байнгын зөвлөл болон Тамгын газар, Санхүү бүртгэлийн газар тогтмол, түүний хэрэгжилтэд ажлын хэсэг хяналт тавина", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Капитал банкны эрх хүлээн авагчаас хүлээж авсан хөрөнгийн 20.0 хувиас доошгүйг зарж борлуулах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах албан шаардлага хүргүүлэх.

2. Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 110,781.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 10.2 сая төгрөгийн зөрчилд 12 төлбөрийн акт тогтоож, 11,087.3 сая төгрөгийн зөрчилд 26 албан шаардлага хүргүүлж, 4,648.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 46 зөвлөмж өгсөн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11-д "төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах",

<sup>1</sup> Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



14 дүгээр зүйлийн 14.2.10-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрсдэлд суурилсан дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөө боловсруулж, батлуулан гүйцэтгэх, харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийг 20.0 хувиас доошгүй бууруулах албан шаардлагыг НДҮЗ-д хүргүүлэх.

### 5.3 Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчил

#### 5.3.1 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл

##### Албан шаардлага

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгэн хүргүүлээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх"; гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн хугацаанд санхүүгийн тайланг бэлтгэн хүргүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх

##### Зөвлөмж

###### 1.1 Илрүүлэлт:

Санхүүгийн ажилтны мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтын төлбөрт 0.2 сая төгрөгийг төлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

###### 1.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, тэвчиж болох зардлыг гаргахгүй байх.

###### 2.1 Илрүүлэлт:

Шилэн дансанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 313,261.2 мянган төгрөгийн 7 зарлагын гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, 113,635.8 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээг байршуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцээгүй.

###### 2.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны байршуулах мэдээллийн хугацаанд нь бүрэн байршуулж байх зөвлөмж өгөх

#### 5.3.2 Нийгмийн даатгалын төв сан

##### Албан шаардлага

1.НДҮЗ-ийн 2018 оны "мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг батлах тухай" 13 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд байршуулах хүүгийн хэмжээг 14.0 хувь, 2023 оны 22 дугаар тогтоолоор 13.07 хувиас багагүй байхаар тогтоосон байна. Нийгмийн даатгалын сангийн 2022 оны мөнгөн хөрөнгө 691,491.4 сая төгрөгийн үлдэгдлээс 515,000.0 сая төгрөгийг хадгаламж хэлбэрээр арилжааны банканд төвлөрүүлэх

саналыг НДҮЗ хүргүүлсэн ч шийдвэрлэгдээгүй, арилжааны 5 банканд байрших харилцах дансны үлдэгдэлд жилийн 3.0 хувийн хүү тооцогдсон, сангийн хөрөнгийг зохистой удирдаагүй байна. Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн /1994 оны/ 11 дүгээр зүйлийн 11.5-д "Хуримтлалын сангаас арилжааны банканд байршуулах хөрөнгийн хэмжээг санхүү болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монгол банк, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл хамтран тогтооно", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн /2023 оны/ 13 дугаар зүйлийн 13.1-д "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг найдвартай, үр өгөөжтэй, хариуцлагатай, ил тод хараат бус байх зарчмыг баримтлан дараах санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болно: ...", 13.9-т "Нийгмийн даатгалын чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах харилцааг зохицуулсан журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хорооны саналыг үндэслэн Засгийн газар батална" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

2. Монгол банкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй Чингис хаан банканд байршиж буй НДС-ийн мөнгөн хөрөнгө 96,105.8 сая төгрөгөөс тайлант онд шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба 1,189.0 сая төгрөгийг барагдуулсан ба 94,916.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, тус банкттай 2021 онд байгуулсан "Төлбөр тооцооны үүрэг хэсэгчлэн гүйцэтгэх тухай" гэрээний үүрэг хангалтгүй, эрсдэлтэй хэвээр байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.3 "нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлт болон нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Чингис хаан банканд байршиж буй нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Нийгмийн даатгалын төв санд төвлөрүүлэх ажил удаашралтай байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

3. Нийгмийн даатгалын сангийн 2006 оноос үүссэн олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй иргэн, аж ахуй нэгж байгууллага, татан буугдсан банк, даатгалын компани болон нийслэлийн өмчийн харилцааны газраас авах 6,451.1 сая төгрөгийн авлагын үлдэгдлээс 6.3 сая төгрөгийг барагдуулж, үлдэгдэл 6,444.7 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах" ... гэж, Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т "нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах" заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас авах авлагыг хууль хяналтын байгууллагад хандан үе шаттайгаар шийдвэрлэх арга хэмжээ аваагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

4. Нийгмийн даатгалын төв сан нь Капитал банкнаас авах 68,201.5 сая төгрөгийн, "Монгол оркестр" ХХК-аас авах 99.7 сая төгрөгийн түрээсийн авлагууд эрсдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрсдэлтэй байгаа авлагуудыг хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэх арга хэмжээ хангалтгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

5. УИХ-ын 2020 оны "Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай", ЗГ-ын 2020 оны "Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журам"-ыг үндэслэн НДҮЗ-ийн 2020 оны 09, 10 дугаар тогтоолуудаар ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын санд 2021 онд 435,416.0 сая төгрөг, 2022 онд 271,200.0 сая төгрөг буюу нийт 706,616.0 сая төгрөг зарцуулсан асуудлыг УИХ, ЗГ-т хандаж шийдвэрлээгүй байна. Энэ нь /1994 оны/ Нийгмийн даатгалын тухай хуулийн 11. 2-т "Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулах, зориулалт бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно"; /2023 оны/ Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулах, нэгтгэх, зориулалтын бусаар ашиглахыг хориглоно" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулсан асуудлыг УИХ болон ЗГ-т хандаж шийдвэрлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

### **Зөвлөмж**

#### 3.1 Илрүүлэлт:

Капитал банкны эрх хүлээн авагчаас авлага барагдуулан хүлээн авсан хөрөнгүүдээс 2021 онд 2,260.2 сая төгрөгийн 6 хөрөнгө, 2022 онд 676.4 сая төгрөгийн 23 хөрөнгө нийт 2,936.6 сая төгрөгийн хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаа болон хөрөнгө зуучлалаар 3-5 удаа борлуулахаар арга хэмжээ авсан ч борлуулагдаагүй байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т "нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### 3.2 Өгсөн зөвлөмж:

Авлагад тооцон авсан хөрөнгийг мөнгөн хөрөнгө болгох ажлыг эрчимжүүлж, сангийн эх үүсвэрийг бий болгох.

#### 4.1 Илрүүлэлт:

Эрх хүлээн авагчаас авлага тооцуулан авсан оффисын зориулалттай байрыг ТӨБЗГ-ын тогтоосон түрээсийн төлбөрийн доод хязгаараас доогуур түрээслүүлж, нийт 164.4 сая төгрөгийн түрээсийн орлого олох боломжийг алдсан байна. Тухайлбал: /СБД-ын хүүхдийн амралтын газрын 3240 м<sup>2</sup>-аас 156.8 сая, Хүнсний сүлжээ дэлгүүр 528 м<sup>2</sup>-аас 19.9 сая/. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" гэсэн заалттай нийцээгүй;

#### 4.2 Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах, холбогдох байгууллагаас тогтоосон түрээсийн төлбөрийн доод хязгаарыг баримталж түрээсийн гэрээг байгуулах

4.1 Илрүүлэлт 2006 оноос хуримтлагдсан эзэн холбогдогч нь тодорхойгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 39,491.8 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх";

4.2 Өгсөн зөвлөмж: Тус өглөгийг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулах зөвлөмж өгөх

### **5.3.3 Нийгмийн даатгалын мэдээлэл технологийн төв Зөвлөмж**

СНАГ-2024/11/НА-СТА-ТЕЗ



**5.1 Илрүүлэлт:**

Мобиком корпорац ХХК-д 30.9 сая төгрөг, Юнител ХХК-д гэр интернэтийн төлбөрт 33.0 сая төгрөг, Топнет ХХК-д 72.9 сая төгрөг, нийт 138.8 сая төгрөгийг интернэтийн үйлчилгээнд зарцуулсан нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-д "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", ТӨБОНӨХБАҮХАТ хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д "Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ", Засгийн газрын 2021 оны 124 дүгээр "Босго үнэ шинэлэх батлах тухай" тогтоолын худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнийн 3-д "Харьцуулалтын аргаар ажил үйлчилгээ гүйцэтгэх төсөвт өртгийн дээд хязгаар бараа 70.0 сая төгрөг"; 2-т шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**5.2 Өгсөн зөвлөмж:**

Төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш 10 хоногийн дотор боловсруулж байх.

**6.1 Илрүүлэлт:**

Тайлант онд хөрөнгө оруулалт болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй бараа, ажил, үйлчилгээг нээлттэй тендер сонгон шалгаруулалгүй хэсэгчлэн хуваан 2 аж, ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулж, 284.6 сая төгрөгийн шилэн кабелийн ажил гүйцэтгүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-д "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", ТӨБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэнд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", 48 дугаар зүйлийн 48.1-д "Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй.

**6.2 Өгсөн зөвлөмж:**

Худалдан авах ажиллагааг босго үнийг баримтлан, аргыг зөв сонгон зохион байгуулж байх

**7.1 Илрүүлэлт:**

Мэдээллийн технологийн төвийн захирлын 2023 оны Б/02, Б/22 тушаалуудаар төрийн үйлчилгээний 12 ажилтны үндсэн цалинг тогтоохдоо цалингийн доод жишгийг тогтоосон тогтоолын шатлалаас 2-3 дахин нэмэгдүүлэн тогтоосон байна. Энэ нь Засгийн газрын 2022 оны 107 тогтоолын 7 дугаар хавсралт, 2023 оны 241 дүгээр тогтоолын 10 дугаар хавсралт тус тус нийцээгүй байна.

**7.2 Өгсөн зөвлөмж:**

Бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа нарийн мэргэжлийн албан хаагчдын цалинтай дүйцүүлэх хууль эрх зүйн орчныг судалж, дээд шатны захирагчаар асуудлыг шийдвэр гаргуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

№	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
		Тоо		Дүн		Тоо		Дүн		Залруулсан		Залруулаагүй		Тоо	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13		
1	Нийгмийн даатгалын төв сан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-		
2	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-		
3	НДЕГ-ын Мэдээлэл технологийн төв	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-		
4	Нийгмийн даатгалын ерөнхий газар	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-		
5	БНУСУ дахь НДА	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-		
6	Нийслэлийн НДХ	6	11.6	-	-	6	11.6	6	11.6	-	-	-	-		
7	Багануур дүүргийн НДХ	2	9.2	2	9.2	-	-	2	9.2	2	9.2	2	9.2		
8	Багахангай дүүргийн НДХ	5	6,673.6	2	6,664.3	3	9.3	3	6,665.0	2	8.6	2	8.6		
9	Баянгол дүүргийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-		
10	Баянзүрх дүүргийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-		
11	Налайх дүүргийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-		
12	Сонгинохайрхан дүүргийн НДХ	3	14.7	-	-	3	14.7	3	14.7	-	-	-	-		
13	Сүхбаатар дүүргийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-		
14	Хан-Уул дүүргийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-		
15	Чингэлтэй дүүргийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-		
16	Архангай аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-		
17	Баян-Өлгий аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-		
18	Баянхонгор аймгийн НДХ	2	13.4	-	-	2	13.4	2	13.4	-	-	-	-		
19	Булган аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-		
20	Говь-Алтай аймгийн НДХ	2	2.3	1	-	1	2.3	1	2.3	-	-	-	-		
21	Говь-сүмбэр аймгийн НДХ	9	33.6	4	17.7	5	15.8	9	33.6	-	-	-	-		
22	Дархан-Уул аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-		
23	Дорноговь аймгийн НДХ	2	2.7	1	1.1	1	1.7	2	2.4	1	0.4	1	0.4		



№	Төрөл, аймаг/ноёд	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл	Төрөл
24	Дорнод аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
25	Дундговь аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
26	Завхан аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
27	Сүхбаатар аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
28	Орхон аймгийн НДХ	4	0.0		4	0.0		4	0.0		4	0.0		4	0.0		4	0.0		4
29	Өвөрхангай аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
30	Өмнөговь аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
31	Сэлэнгэ аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
32	Төв аймгийн НДХ	1	1.0	1	1.0		1	1.0		1	1.0		1	1.0		1	1.0		1	1.0
33	Увс аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
34	Ховд аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
35	Хэнтий аймгийн НДХ	1	1.5		1	1.5		1	1.5		1	1.5		1	1.5		1	1.5		1
36	Хөвсгөл аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>		<b>37</b>	<b>6,763.7</b>	<b>11</b>	<b>6,693.3</b>	<b>26</b>	<b>70.4</b>	<b>32</b>	<b>6,745.6</b>	<b>5</b>	<b>18.1</b>	<b>5</b>	<b>18.1</b>	<b>5</b>	<b>18.1</b>	<b>5</b>	<b>18.1</b>	<b>5</b>	<b>18.1</b>	<b>5</b>

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нийгмийн даатгалын төв сан	7	98,057.5			4	94,916.9	3	3,140.7				
2	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл	2	0.3					1	0.3	1			
3	НДЭГ-ын Мэдээлэл технологийн төв	3	423.5					3	423.5				
4	Нийгмийн даатгалын ерөнхий газар	9	514.3			4	373.7	4	140.6	1			
5	БНУСУ дахь НДА	-	-										
6	Нийслэлийн НДХ	3	47.6	1	1.1			2	46.6				
7	Багануур дүүргийн НДХ	1	424.1					1	424.1				

Үүнээс

сая төгрөгөөр

8	Багахангай дүүргийн НДХ	1	13.4					1	13.4				
9	Баянгол дүүргийн НДХ	-	-										
10	Баянзүрх дүүргийн НДХ	3	9,083.5					3	9,083.5				
11	Налайх дүүргийн НДХ	3	201.8					1	0.5	2	201.3		
12	Сонгинохайрхан дүүргийн НДХ	4	4.5							4	4.5		
13	Сүхбаатар дүүргийн НДХ	4	18.0							4	18.0		
14	Хан-Уул дүүргийн НДХ	1	39.3							1	39.3		
15	Чингэлтэй дүүргийн НДХ	2	-							2	-		
16	Архангай аймгийн НДХ	2	32.6					2	32.6				
17	Баян-Өлгий аймгийн НДХ	-	-										
18	Баянхонгор аймгийн НДХ	3	29.8					2	29.8	1	-		
19	Булган аймгийн НДХ	3	2.0	2						1	-		
20	Говь-Алтай аймгийн НДХ	1	-							1	-		
21	Говь-сүмбэр аймгийн НДХ	9	147.9	1				7	146.2	1	-		
22	Дархан-Уул аймгийн НДХ	1	2.1	1									
23	Дорноговь аймгийн НДХ	-	-										
24	Дорнод аймгийн НДХ	1	1.3					1	1.3				
25	Дундговь аймгийн НДХ	3	1.9	2			0.1			1	1.8		
26	Завхан аймгийн НДХ	3	24.9							3	24.9		
27	Сүхбаатар аймгийн НДХ	1	-							1	-		
28	Орхон аймгийн НДХ	4	14.8	2			1.2	1	13.6	1	-		
29	Өвөрхангай аймгийн НДХ	-	-										
30	Өмнөговь аймгийн НДХ	1	6.9							1	6.9		
31	Сэлэнгэ аймгийн НДХ	6	247.5	1			1.2	2	246.3	3	-		
32	Төв аймгийн НДХ	4	1,121.7	1			0.5	1	1,120.8	2	0.4		
33	Увс аймгийн НДХ	-	-										
34	Хөвд аймгийн НДХ	1	0.6							1	0.6		
35	Хэнтий аймгийн НДХ	2	26.0	1			0.4	1	25.7				
36	Хөвсгөл аймгийн НДХ	-	-										
	<b>Дүн</b>	<b>88</b>	<b>110,487.8</b>	<b>12</b>	<b>10.2</b>	<b>30</b>	<b>106,004.2</b>	<b>44</b>	<b>4,473.4</b>				

ТОРИЙН АУДИТЫН БАЙГУУЛАГА  
**01**  
**ХЯЗГААРЛАЛТАЙ**  
**САНАЛ ДҮНЭЭТ**

**2**

11	Налайх дүүргийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
12	Сонгинохайрхан дүүргийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
13	Сүхбаатар дүүргийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
14	Хан-Уул дүүргийн НДХ	1	-	-	1.6	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	1.6
15	Чингэлтэй дүүргийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
16	Архангай аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
17	Баян-Өлгий аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
18	Баянхонгор аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
19	Булган аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
20	Говь-Алтай аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
21	Говь-сүмбэр аймгийн НДХ	3	-	-	2.7	-	-	-	1	-	2.1	2	-	-	-	-	-	-	-	-	0.7
22	Дархан-Уул аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
23	Дорноговь аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
24	Дорнод аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
25	Дундговь аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
26	Завхан аймгийн НДХ	1	-	-	0.2	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	0.2
27	Сүхбаатар аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
28	Орхон аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
29	Өвөрхангай аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
30	Өмнөговь аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
31	Сэлэнгэ аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
32	Төв аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
33	Увс аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
34	Ховд аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
35	Хэнтий аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
36	Хөвсгөл аймгийн НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн		10	-	-	67.8	-	-	-	1	0.5	3	-	-	-	-	-	-	-	-	-	12.5
Нийт дүн		27	-	-	2,912.7	-	-	-	1	0.5	8	18	-	-	-	-	-	-	-	-	1,841.7
													54.9	1,070.5							





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 дугаар сарын 25

№ 938/АД 130036

Улаанбаатар хот

СНАГ - 2024/326/НА - СТБ - ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгэн төрийн аудитын байгууллагад хүргүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хуулийн хугацаанд санхүүгийн тайланг бэлтгэн төрийн аудитын байгууллагад хүргүүлээгүй нягтлан бодогч О.Батцэцэгт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны дарга /Г.Банзрагч/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



НАРАНЧИМЭГ  
ХОСЖАРГАЛ  
ЭРДЭНЭЦОГТ  
ОТГОНХОРЛОО



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 дугаар сарын 25 № 940/А0121241  
СНАР-2024/11/НА-СТА-ТЭС  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 110,601,396,000.00 /нэг зуун арван тэрбум зургаан зуун нэг сая гурван зуун ерэн зургаан мянган/ төгрөгийн зөрчил илэрснээс 10,225,200.00 /арван сая хоёр зуун хорин таван мянга хоёр зуун/ төгрөгийн зөрчилд 12 төлбөрийн акт тогтоож, 11,087,305,300.00 /арван нэгэн тэрбум наян долоон сая гурван зуун таван мянга гурван зуун/ төгрөгийн зөрчилд 26 албан шаардлага хүргүүлж, 4,473,354,700.00 /дөрвөн тэрбум дөрвөн зуун далан гурван сая гурван зуун тавин дөрвөн мянга долоон зуун/ төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 46 зөвлөмж өгсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11-д "төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах", 14 дүгээр зүйлийн 14.2.10-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн нөхцөл байдал" заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрсдэлд суурилсан дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөө боловсруулж, батлуулан гүйцэтгэх, харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийг 20.0 хувиас доошгүй бууруулж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга /Х.Булгантуяа/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Л.Мөнхзул/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Зэрэс, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264280

Z:\Alban Shaardlaga\2024\0425 SNAГ-31.Docx

0001081600



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 дугаар сарын 25 № 94/А0121241  
СНАГ-2024-Н-НА-СТА-ТЭС  
Зөрчил арилгах тухай

Үлээнбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын Үндэсний Зөвлөлийн 2021 оны 24, 2022 оны 01 тогтоолуудаар Капитал банкны эрх хүлээн авагчаас хүлээж авсан хөрөнгөөс 15,084,063,268.14 /арван таван тэрбум наян дөрвөн сая жаран гурван мянга хоёр зуун жаран найман төгрөг арван дөрвөн мөнгө/ төгрөгийн үндсэн хөрөнгө борлогдоогүй байгаа нь цаашид ашиглалтгүй хөрөнгө нэмэгдэх эрсдэлтэй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын Үндэсний Зөвлөлийн 2021 оны 18 дугаар тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам"-ын 4.3-т "хөрөнгийн хадгалалт хамгаалалтад Нийгмийн даатгалын ерөнхий газрын өмч хамгаалах байнгын зөвлөл болон Тамгын газар, Санхүү бүртгэлийн газар тогтмол, түүний хэрэгжилтэд ажлын хэсэг хяналт тавина", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Капитал банкны эрх хүлээн авагчаас хүлээж авсан хөрөнгийн 20.0 хувиас доошгүйг зарж борлуулах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга /Х.Булгантуяа/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Л.Мөнхзүл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ЗАГДЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 дугаар сарын 25 № 942/А0121241  
СИАР-2024/373/НА-СТА-ТШЗ  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын төв сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол банкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй Чингис хаан банканд байршиж буй НДС-ийн мөнгөн хөрөнгө 96,105,875,200.00 /ерэн зургаан тэрбум нэг дуун таван сая найман зуун далан таван мянга хоёр зуун/ төгрөгөөс тайлант онд шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба 1,189,000,000.00 /нэг тэрбум нэг зуун наян есөн сая/ төгрөгийг барагдуулсан ба 94,916,875,000.00 /ерэн дөрвөн тэрбум есөн зуун арван зургаан сая найман зуун далан таван мянган/ төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, тус банктай 2021 онд байгуулсан "Төлбөр тооцооны үүрэг хэсэгчлэн гүйцэтгэх тухай" гэрээний үүрэг хангалтгүй, эрсдэлтэй хэвээр байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.3 "нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлт болон нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Чингис хаан банканд байршиж буй нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Нийгмийн даатгалын төв санд төвлөрүүлэх ажил удаашралтай байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга /Х.Булгантуяа/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Л.Мөнхзүл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойрог-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264280

Z:\Alban Shaardiaga\2024\9425 SIAG-31.Docx

0001081631



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 дугаар сарын 25 № 943/А0121241  
СНАП-2024/373/НА-СТА-ТШЗ  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хс.

Төрийн аудитын тухай, хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын төв сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын төв сан нь Капитал банкнаас авах 68,201,545,600.00 /жаран найман тэрбум хоёр зуун нэг сая таван зуун дөчин таван мянга зургаан зуун/ төгрөгийн, "Монгол оркестр" ХХК-аас авах 99,757,500.00 /ерэн есөн сая долоон зуун тавин долоон мянга таван зуун/ төгрөгийн түрээсийн авлагууд эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, ер төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрсдэлтэй байгаа авлагуудыг хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэх арга хэмжээ хангалтгүй байгаа зөрчлийг арилгаж, авлагыг 10 хувиас доошгүй бууруулах, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга /Х.Булгантуяа/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Л.Мөнхзул/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 дугаар сарын 25 № 944/А01212-41  
СНАГ-2024/373/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуудийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын сангийн 2006 оноос үүссэн олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй иргэн, аж ахуй нэгж байгууллага, татан буугдсан банк, даатгалын компани болон нийслэлийн өмчийн харилцааны газраас авах 6,451,154,200.00 /зургаан тэрбум дөрвөн зуун тавин нэгэн сая нэг зуун тавин дөрвөн мянга хоёр зуун/ төгрөгийн авлагын үлдэгдлээс 6,370,000.00 /зургаан сая гурван зуун далан мянган/ төгрөгийг барагдуулж, үлдэгдэл 6,444,784,200.00 /зургаан тэрбум дөрвөн зуун дөчин дөрвөн сая долоон зуун наян дөрвөн мянга хоёр зуун/ төгрөгийн авлагыг барагдуулах талаар хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах" ... гэж, Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т "нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах" заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас авах авлагыг хууль хяналтын байгууллагад хандан үе шаттайгаар шийдвэрлэх арга хэмжээ авч, авлагыг 10 хувиас доошгүй бууруулах, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга /Х.Булгантуяа/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Л.Мөнхзул/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Ингэжигүүр дүүрэг, 1-р хороо, Баха тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2024\0425 SNAG-31.Docx

0001081595



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 дугаар сарын 25

№ 945/А0121241

Улаанбаатар хот

СНАГ- 2024/373/НА-СТА-ТМС  
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын төв сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын Үндэсний Зөвлөлийн 2018 оны "мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг батлах тухай" 13 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд байршуулах хүүгийн хэмжээг 14.0 хувь, 2023 оны 22 дугаар тогтоолоор 13.07 хувиас багагүй байхаар тогтоосон байна. Нийгмийн даатгалын сангийн 2022 оны мөнгөн хөрөнгө 691,491,451,700.00 /зургаан зуун ерэн нэгэн тэрбум дөрвөн зуун ерэн нэрэн сая дөрвөн зуун тавин нэгэн мянга долоон зуун/ төгрөгийн үлдэгдлээс 515,000,000,000.00 /таван зуун арван таван тэрбум/ төгрөгийг хадгаламж хэлбэрээр арилжааны банканд төвлөрүүлэх саналыг Нийгмийн даатгалын Үндэсний Зөвлөл хүргүүлсэн ч шийдвэрлэгдээгүй, арилжааны 5 банканд байрших харилцах дансны үлдэгдэлд жилийн 3.0 хувийн хүү тооцогдсон, сангийн хөрөнгийг зохистой удирдаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн /1994 оны/ 11 дүгээр зүйлийн 11.5-д "Хуримтлалын сангаас арилжааны банканд байршуулах хөрөнгийн хэмжээг санхүү болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монгол банк, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл хамтран тогтооно", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн /2023 оны/ 13 дугаар зүйлийн 13.1-д "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг найдвартай, үр өгөөжтэй, хариуцлагатай, ил тод хараат бус байх зарчмыг баримтлан дараах санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болно: ...", 13.9-т "Нийгмийн даатгалын чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах харилцааг зохицуулсан журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хорооны саналыг үндэслэн Засгийн газар батална" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын Үндэсний Зөвлөлийн дарга /Х.Булгантуяа/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Л.Мөнхзул/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ЗАГДЖАВ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 дугаар сарын 25 № 968/А0121241  
СНАГ - 2024/373 | ИА - СТА - ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын төв сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын Их Хурлын 2020 оны "Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай", Засгийн газрын 2020 оны "Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журам"-ыг үндэслэн Нийгмийн даатгалын Үндэсний Зөвлөлийн 2020 оны 09, 10 дугаар тогтоолуудаар Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын санд 2021 онд 435,416,000,000.00 /дөрвөн зуун гучин таван тэрбум дөрвөн зуун арван зургаан сая/ төгрөг, 2022 онд 271,200,000,000.00 /хоёр зуун далан нэгэн тэрбум хоёр зуун сая/ төгрөг буюу нийт 706,616,000,000.00 /долоон зуун зургаан тэрбум зургаан зуун арван зургаан сая/ төгрөг зарцуулсан асуудлыг Улсын Их Хурал, Засгийн газарт хандаж шийдвэрлээгүй байна.

Энэ нь /1994 оны/ Нийгмийн даатгалын тухай хуулийн 11. 2-т "Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулах, зориулалт бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно"; /2023 оны/ Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулах, нэгтгэх, зориулалтын бусаар ашиглахыг хориглоно" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулсан асуудлыг Улсын Их Хурал, Засгийн газарт хандаж шийдвэрлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга /Х.Булгантуяа/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Л.Мөнхзул/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264430

Z:\Alban Shaardlaga\2024\0425 SNAГ-31.Docx

0001081635